



БОЛОВСРОЛЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮР НӨЛӨӨ, ҮР ДҮНД БҮТЭЦЧИЛЭГДСЭН АЖИГЛАЛТЫН ОРУУЛАХ ХУВЬ НЭМЭР

Др.Бернхард Нагел^а

^аХБНГУ, Нойбранденбургийн их сургуулийн зочин профессор

Холбоо барих зохиогч:Bernhard.Nagel@extern.lrz-muenchen.de 

Хүлээн авсан: 2025.08.25

Хянагдсан: 2025.09.25

Зөвшөөрсөн: 2025.11.05

Хураангуй

Улс орнууд олон улсын харьцуулсан судалгаа (жишээ нь, PISA судалгаа)-нд оролцон, түүний тусламжтайгаар боловсролын тогтолцоо, сурган хүмүүжүүлэх арга барилын үр нөлөө, үр дүнгийн талаар хэлэлцэж байгаа ч сургуулийн өмнөх боловсролын салбарт энэ нь хомс байна. Энэ нь зарим талаар сургуулийн өмнөх боловсролын байр суурь түүнчлэн хүүхдэд ээлтэй арга барилтай холбоотой.

Хүүхдийн хөгжилд зориулсан бүтэцчилэгдсэн ажиглалтын арга нь (ажиглалтын хуудас ашиглах) зардал багатайгаар маш олон тооны хүүхдийн хөгжлийн талаар үнэн зөв, найдвартай өгөгдөл (statements) бий болгоход тохиромжтой. Энэ нь боловсролын бодлогын арга хэмжээ болон хүүхдийн хөгжлийн ахиц дэвшлийн хоорондын уялдаа холбоог судлах чухал урьдач нөхцөл юм.

Монгол Улсын хүүхдийн хөгжлийн ажиглалтын хуудасны жишээ болон Герман улсын цэцэрлэгт хийгдсэн нэмэлт санхүүгийн эх үүсвэрийг ашиглан, үр дүн, үр нөлөөг тооцсон судалгаанд суурилан, сургуулийн өмнөх боловсролын салбарын арга хэмжээнд бүтэцлэгдсэн ажиглалтын тусламжтайгаар дүгнэлт хийх боломжтойг харуулахыг зорьсон.

Түлхүүр үг

бүтэцчилэгдсэн ажиглалтын арга, боловсролын үр дүн (efficiency), үр нөлөө (effectiveness)

Удиртгал

Үр нөлөө ба үр дүн

Сургуулийн өмнөх боловсролын салбарт хэрэгжиж буй боловсролын арга хэмжээний үр дүн, үр нөлөөний талаарх асуултын үр нөлөө гэдэг үг нь “Бүтцийн, материаллаг болон ажиллах хүчинтэй холбоотой арга хэмжээ нь хүүхдийн хөгжил,

боловсролд бодитоор дэмжлэг, нөлөөлөл үзүүлж байна уу?” гэсэн асуулттай холбогдоно. Үр дүнгийн тухайд бол “бүтцийн, материаллаг болон ажиллах хүчний талаарх авсан арга хэмжээг хүүхдийн хөгжил, боловсролын үр дүн нь аль болох сайн байхаар ашиглаж байна уу гэсэн асуултад чиглэнэ.

Бүтцийн чанар гэдэг нь байгууллагын доторх бүтэц болон ерөнхий орчин нөхцөл, үйл явцын чанар гэдэг нь тухайн сурган хүмүүжүүлэгч, эцэг эхийн үзүүлж буй үйлчилгээний төрөл, хариу үйлдэл бөгөөд эдгээрийг харьцангуй хялбар тогтоох боломжтой бөгөөд харин үр дүнгийн чанарыг тогтооход амаргүй байдаг.

Сургуулийн хэмжээнд ангиуд зорилгодоо хүрсэн эсэхийг ихэвчлэн сургуулийн гүйцэтгэлийн тест, шалгалтын гүйцэтгэлээр үнэлдэг. Эдгээр үнэлгээний дүнгээр сургууль болон ангиудыг хооронд нь харьцуулан судалж болдог.

Сургуулийн өмнөх боловсролын салбарт энэ нь илүү хэцүү байдаг. Учир нь олон орон заавал дагаж мөрдөх сургалтын хөтөлбөргүй, харин чадамжид чиглэсэн сургалт, хүмүүжлийн хөтөлбөртэй байдаг. Энэ нь хүүхдийн хөгжлийн нас, авьяас чадварт нь тохируулан, аль болох ихийг хийж чаддаг болоход нь дэмжлэг үзүүлдэг гэсэн үг юм.

Дараах зураг нь сурган хүмүүжүүлэх ажлын чанар нь бүтэц, материаллаг болон ажиллах хүчний нөхцөлөөс хэрхэн хамаардгийг харуулна. Сурган хүмүүжүүлэх ажлын чанар нь эргээд хүүхдийн хөгжилд нөлөөлдөг. Сургуулийн өмнөх боловсролын салбарын боловсролын бодлогын арга хэмжээ нь сурган хүмүүжүүлэх ажлын чанарыг сайжруулах замаар хүүхдийн хөгжлийг илүү сайн дэмжиж, нөлөөлөх ёстой.

A. Бүтцийн нөхцөл



B. Материаллаг нөхцөл



C. Ажиллах хүчний нөхцөл



D. Сурган хүмүүжүүлэх ажлын чанар



E. Хүүхдийн хөгжил

Хэрэв авсан арга хэмжээ үр нөлөөтэй бол хүүхдийн хөгжлийг дэмжинэ. Хэрэв тэдгээр нь үр дүнтэй байвал хүүхдийн хөгжлийг сайжруулна. Үүнийг тодорхойлоход хүүхдийн хөгжилд стандартчилсан баримтжуулалт хийх боломжийг олгодог аргачлал шаардлагатай. Мөн арга хэмжээний нөлөөллийг тодорхойлохын тулд хэдэн жилийн турш цугларсан баримтжуулсан мэдээллийг харьцуулах боломжтой байх ёстой. Зарчмын хувьд үүнд тест, ажиглалтын арга тохиромжтой.

Тест ба ажиглалтын арга

Чанарын асуудлыг авч үзэх бүх аргад зайлшгүй анхаарах зүйлс бий. Үүнд:

- Онолын суурь: Арга нь судалгааны өнөөгийн байдалтай тохирч байх ёстой. Өөрөөр хэлбэл, энэ нь мэдлэгийн өнөөгийн байдалд тохирсон байх ёстой бөгөөд шинжлэх ухаанаар хүлээн зөвшөөрөгдсөн онолуудтай нягт холбоотой байна.
- Эмпирик баталгаажуулалт: Энэ нь судлагдсан арга мөн үү? Энэ арга нь «объектив байдал», «найдвартай байдал», «хүчин төгөлдөр байдал» гэсэн эмпирик судалгааны шалгуурыг хангаж байна уу? Асуултуудын сонголт нь “хөгжлийн чиглэл”, хүүхдийн хөгжилтэй нийцэж байна уу?
- Анхан шатны боловсролын сургалтын хөтөлбөрт нийцсэн байдал: Арга нь сургалтын хөтөлбөрт заасан боловсролын тодорхой зорилго болон байгууллагын үзэл баримтлал, тэргүүлэх чиглэлтэй агуулгын хувьд холбоотой байна уу?
- Практикт хэрэгжүүлэх боломж: Арга нь хэр зэрэг төвөгтэй байна вэ? Сургуулийн өмнөх байгууллагын сурган хүмүүжүүлэх ажлыг дэмжихээр байна уу? Энэ нь цэцэрлэгийн багш нараас гадна эцэг эхчүүдэд хэр ойлгомжтой байна вэ? Үүнд «лабораторийн нөхцөл байдал» шаардлагатай юу эсвэл үүнийг өдөр тутмын амьдралд ашиглах боломжтой юу? Мэргэжлийн ямар чадамж шаардлагатай вэ? Хэр зэрэг хүлээн зөвшөөрөгдөж байна вэ?

Хэрэв сонгодог стандартчилагдсан тестийн аргыг стандартчилагдсан ажиглалтын аргатай харьцуулж үзвэл бага насны хүүхдийн хувьд сонгодог стандартчилагдсан тестийн аргын сул тал нь амархан тодорно.

Тестийн сул тал

- Тохиромжтой тестийн арга тун цөөн.
- Тестийн нөхцөл байдалд хүүхэд дасаагүй байдаг. Хүүхэд жинхэнэ боломжоо харуулахгүй байх эрсдэлтэй.
- Хүүхдийг тестээр шалгах нь ганцаарчилсан ажиллагаа шаарддаг тул ачаалал ихтэй.
- Бүлгийн нийт хүүхдийг тестэд хамруулахад зохих ёсоор урьдчилан бэлтгэсэн олон тооны мэргэжилтэн шаардагддаг тул зардал ихтэй.

Бүтэцчилэгдсэн ажиглалтын давуу тал:

- Ажиглалт явуулах тодорхой удирдамжтай.
- Ажиглах хөгжлийн чиглэлүүдээр тодорхой асуултуудтай.
- Ажиглалтын тодорхой чиглэлүүдтэй.
- Тодорхой тайлбарласан ажиглалтын агуулгатай.
- Ажиглалт нь стандартчилагдсан учраас харьцуулах боломжтой.
- Ажиглагч багш нарт зориулсан стандартчилсан сургалттай.
- Тоон болон чанарын үнэлгээ хийх боломжтой.
- “Ажиглалтын мэдлэг”-ийг тодорхойлох боломжтой.
- Өдөр тутмын амьдралын явцад ажиглалт хийгддэг тул лабораторийн нөхцөл шаардахгүй.
- Ажиглалтыг удирдан чиглүүлж болдог.
- Мэргэжлийн ур чадварыг баталгаажуулахад илүү хялбар.
- Хэрэгжүүлэлт, үнэлгээ нь харьцангуй хялбар.
- Үр дүнг танилцуулахад илүү хялбар.

- Янз бүрийн цаг хугацааны ажиглалтыг хялбархан харьцуулах боломжтой.
- Ажиглалтын сүлжээ (raster) нь баг хамт олныг “нийтлэг нэг хэл яриа” рүү хөтөлдөг.
- Өөр өөр багшийн ажиглалтыг цуглуулж, ангилахад хялбар.

Ажиглалтын хуудас

Монгол Улсын сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөрийн хүрээнд хүүхдийн хөгжлийг ажиглах, улсын хэмжээнд харьцуулах боломжтой стандартчилагдсан ажиглалтын аргыг боловсруулсан байдаг. Ажиглалтын үр дүнг орон нутаг (жишээ нь, хот-хөдөө) болон цаг хугацаа (хэдэн жил)-ны аль алинаар нь харьцуулах боломжийг олгосон.

Ажиглалт нь хөгжлийн долоон хэсэгт хуваагддаг.

- (1) Хөдөлгөөн, эрүүл мэндийн чадамж
 1. Биеийн хөдөлгөөнөө удирдах
 2. Гар хурууны хөдөлгөөнөө зохицуулах
 3. Эрүүл мэндээ хамгаалах
- (2) Нийгэмшихүйн чадамж
 1. Зан чанар
 2. Сэтгэлийн хөдөлгөөний чадамж
 3. Бусадтай харилцах
- (3) Хэл ярианы чадамж
 1. Сонсох, ойлгох
 2. Ярих
 3. Унших, бичих бэлтгэл
- (4) Орчинтойгоо харилцах чадамж
 1. Орчноо шинжлэн судлах
 2. Орчинтойгоо харьцах
- (5) Математикийн чадаж
 1. Тоолох
 2. Хэмжих
- (6) Дүрслэх урлагийн чадамж
 1. Зурах
 2. Урлах
- (7) Хөгжмийн чадамж
 1. Дуулах, хөгжимдөх
 2. Бүжиглэх, жүжиглэх

Энэхүү аргаар хэдэн жилийн туршид хүүхэд бүрийн хөгжлийн явцыг баримтжуулах боломжтой болсон. Стандартчиллаар наснаас нь үл хамааран, хүүхдийн хөгжлийн ахиц дэвшлийг тодорхойлох боломжтой.

Үүгээр боловсролд авч буй арга хэмжээнүүдийн өөрчлөлтүүдийн нөлөөллийг шалгах үндсэн урьдач нөхцөлийг бүрдүүлсэн.

ХБНГУ-ын Мюнхен хотын цэцэрлэгүүдэд боловсролын бодлогын арга хэмжээний нөлөөллийг стандартчилсан ажиглалтын хуудсыг ашиглан судалсан. Мюнхений судалгааны зорилго нь нэмэлт хөрөнгө мөнгөний нөлөөллийг үнэлэх явдал байв. Байгууллагуудад мөнгийг янз бүрийн хэлбэрээр ашиглах боломж олгосон бөгөөд тэрхүү мөнгөний зарцуулалтын талаарх асуулт нь бүтэц, материаллаг байдал, ажиллах хүчин, тэдгээрийн алиных нь өөрчлөлт илүү үр нөлөөтэй, үр дүнтэй байгааг илрүүлэхэд чиглэсэн асуулт давамгайлж байв.

Дараах схем нь (А) нэмэлт санхүүгийн эх үүсвэрээр хангаж, (В) өгсөн нөөцийг ашиглан (С) бүтцийн өөрчлөлт хийснээр, (D) олон чиглэлээр боловсролын чанар сайжирч (E), хүүхдийн чадамж дээшилсэн гинжин хэлхээг харуулж байна.

A. Байгууллагуудад нэмэлт санхүүжилт олгосон



B. Нэмэлт санхүүгийн эх үүсвэрийг тухайн байгууллага өөрсдийн тодорхой эрэлт хэрэгцээндээ нийцүүлэн ашигласан



C. Байгууллагын нэмэлт санхүүгийн эх үүсвэр нь байгууллагын бүтцийн өөрчлөлтөд хүргэсэн



D. Бүтцийн өөрчлөлт нь байгууллагын боловсролын чанарыг сайжруулахад нөлөөлсөн

(сонгосон чанарын талбар:)

1. Түвшин: багш нар
 - a. Хүүхдийн дунд явуулах сурган хүмүүжүүлэх ажил
 - b. Багш-хүүхдийн-харилцаа
 - c. Ажлын уур амьсгал
 - d. Мэргэжлийн хөгжил
 - e. Ажилдаа сэтгэл ханамжтай байгаа байдал
2. Байгууллагын холбоо сүлжээ
3. Эцэг эхтэй хамтран ажиллах ажиллагаа
4. Төхөөрөмж хэрэгсэл



E. Хүүхдүүд өндөр чадамжтай байсан


Хүүхдүүдийн хөгжлийн талаарх мэдээлэл нь сайжруулалтын шалгуур болсон. Бүтэц, материаллаг ба ажиллах хүчний чанарын шалгуур үзүүлэлтүүдийн дагуу нэмэлт мэдээлэл цуглуулснаар хүүхдийн хөгжлийн боломжийг сайжруулахад аль хүчин зүйл нь чухал хувь нэмэр оруулж байгааг тодорхойлох бүрэн боломжтой.

Хүүхдийн хөгжлийн түвшний мэдээллийг судалгааны гурван өөр цаг хугацаанд

хүүхдийн хөгжлийн чиглэлүүдээр стандартчилсан ажиглалтын хуудсыг ашиглан цуглуулсан.

Үүгээр бүтэц, материаллаг болон ажиллах хүчний чанарын шалгуур үзүүлэлтүүдийн дагуу эерэг өөрчлөлтүүдийг тогтоож байсан.

Хүүхдийн чадамж, сонирхлын өсөлт нь хөдөлгөөн, нийгэмшихүй, сэтгэл хөдлөл, сэдэл, хэл яриа, байгалийн шинжлэх ухаан болон дүрслэн урлагийн чиглэлээр статистикаар илэрхий батлагдаж байсан.



(Е) Хүүхдийн чадамж ба сонирхол
Чиглэлүүд (ХБНГУ-ын ажиглалтын хуудасны)

1. Хөдөлгөөний чадамж
2. Нийгэмшихүйн чадамж
3. Сэтгэл хөдлөлийн чадамж
4. Сэдлийн чадамж
5. Хэл яриа ба бичиг үсгийн суурь
6. Математикийн чадамж
7. Байгалийн шинжлэх ухааны чадамж, сонирхол
8. Хөгжмийн чадамж, сонирхол
9. Дүрслэх урлагийн чадамж, сонирхол
10. Эрүүл мэндтэй холбоотой чадамж, сонирхол
11. Сайн сайхан байдал, нийгмийн харилцаа
12. Хөдөлгөөн

Судалгааны үр дүн

1. Ажилтнуудын ажлын нөхцөл сайн байх нь тухайн байгууллага дахь үйл явцын чанарт эергээр нөлөөлдөг. Ялангуяа, багш-хүүхдийн сайн харилцаа түүнчлэн ажилтнуудын ажлын тасалдал бага байх нь «хүүхэдтэй ажиллах» цаг хугацааг нэмэгдүүлж, боловсролын ажилд чухал нөлөө үзүүлдэг. Энэ нь хамран сургах үйл ажиллагаанд мөн адил хамаарна.
2. Үүрэг даалгаврын тодорхой тодорхойлолт, чиг баримжаа нь багш нарын сурган хүмүүжүүлэх ажлыг дэмжиж байсан.
3. Хүн хүчний нөөц сайтай байх нь эцэг эхтэй хамтран ажиллах ажиллагааг сайжруулж байв.
4. Байгууллагадаа мэргэжлээрээ туршлагажсан багш/мэргэжилтнийг авч ажиллуулбал ажлын уур амьсгал илүү эергээр үнэлэгдэхэд нөлөөлдөг.
5. Өөрийн ажлаа эергээр үнэлсэн багш ур чадвараараа сайн байсан бөгөөд энэ нь хоорондоо уялдаатай.
6. Мэргэжлийн санаа оноо (жишээлбэл, хяналт эсвэл нэмэлт сургалтаар) авах боломж нь хүүхдүүдтэй ажиллах сурган хүмүүжүүлэх ажлыг сайжруулж, ажлын нөхцөл байдалд илүү эерэг үнэлгээ өгөхөд нөлөөлж байв.
7. Нэмэлтээр мэргэжилтнүүд ажиллуулснаар тухайн байгууллагын үйл явцын чанарыг сайжруулсан. Ялангуяа, өөр мэргэжилтнүүд (жишээлбэл, хэл засалч, сэтгэл зүйч)-ийг авч ажиллуулснаар илүү ганцаарчилсан, хүртээмжтэй боловсролын ажил явагдах ба ингэснээр хүүхэд тус бүрт илүү тохирсон тодорхой дэмжлэг үзүүлэх боломж бүрддэг.
8. Хүүхдийг илүү эрчимтэй ажиглаж, үнэлэх нь (жишээлбэл, ажиглалтын хуудсыг ашиглан) сургуулийн өмнөх байгууллагын сурган хүмүүжүүлэх ажлын үйл явцыг сайжруулахад нөлөөлдөг бөгөөд юуны түрүүнд хүүхэд тус бүрт зохицсон сурган хүмүүжүүлэх арга зүйн алхмуудыг бий болгодог тул хүүхэд бүрт илүү сайн дэмжлэг үзүүлэх боломж бүрдүүлж байлаа.
9. Цөөхөн тохиолдолд л сургуулийн өмнөх байгууллага болон бага сургуулийн үзэл баримтлал хоорондоо уялдаж байсан. Сургууль дээр сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сурган хүмүүжүүлэх санаа оноо, хүүхдийн хөгжлийн баримтжуулалтыг авч үзэх нь ховор байв.
10. Судалгаагаар сурган хүмүүжүүлэх ажилд өгөгдөлд суурилсан байнгын мониторинг хийх үндэс суурь тавигдсан. Энэ нь үр нөлөө, үр дүнд суурилсан чанарын баталгаатай арга хэмжээний чухал урьдчилсан нөхцөлийг бүрдүүлсэн.
11. Хүүхдийн чадамж, сонирхлын өсөлт нь хөдөлгөөн, нийгэмшихүй, сэтгэл хөдлөл, сэдэл, хэл яриа, байгалийн шинжлэх ухаан болон дүрслэн урлагийн чиглэлээр статистикаар илэрхий батлагдаж байсан.

Дүгнэлт

Монгол болон ХБНГУ-ын сургуулийн өмнөх боловсролын түвшинд хэрэглэдэг ажиглалтын хуудас нь зарчмын хувьд ерөнхийдөө төстэй байна. Монгол Улсын сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөрийн хүрээнд хүүхдийн хөгжлийг ажиглах, улсын хэмжээнд харьцуулах боломжтой стандартчилагдсан ажиглалтын аргыг боловсруулсан байдаг. Ажиглалтын үр дүнг орон зай, цаг хугацаанаас үл хамааран, ашиглаж харьцуулах боломжтой. Ажиглалтыг хүүхдийн хөгжлийн 7 чиглэлээр хийхээс гадна хүүхэд бүрийн хөгжлийн явцыг баримтжуулахад чиглэгдсэн байна. Гол нь наснаас нь үл хамааран, хүүхдийн хөгжлийн ахиц дэвшлийг тодорхойлох боломж бүрдүүлжээ. Энэ нь боловсролын салбарт авч буй арга хэмжээ, түүний нөлөөллийг илрүүлэх урьдач нөхцөлийг бүрдүүлсэн байна.

ХБНГУ-ын Мюнхен хотын цэцэрлэгүүдэд ашигласан стандартчилсан ажиглалтын хуудас нь хүүхдийн хөгжлийн 12 чиглэлээр боловсруулагджээ. Энэхүү ажиглалтын хуудсыг боловсролын бодлогын арга хэмжээний нөлөөллийг судлахад ашиглажээ. Судалгааны зорилго нь нэмэлт хөрөнгө мөнгөний нөлөөллийг үнэлэх явдал байв. Мөнгийг янз бүрийн хэлбэрээр ашиглах боломж олгосон учраас мөнгөний зарцуулалтын талаарх асуулт нь байгууллагын бүтэц, материаллаг байдал, ажиллах хүчин, хүний нөөц зэрэгт гарсан өөрчлөлт, тэдгээрээс аль нь илүү үр нөлөөтэй, үр дүнтэй байсныг ажиглах, илрүүлэхэд чиглэгдсэн байна. Судалгаагаар энэхүү ажиглалтын хуудсаар сургуулийн өмнөх боловсролд авч буй арга хэмжээний үр нөлөө, үр дүнг тооцох боломжтой нь батлагдсан.

Ном зүй

1. Christenson, S. L. & Sheridan, S. M. (2001). School and families: Creating essential connections for learning. New York: The Guilford Press.
2. Bronfenbrenner, U. (1981): Die Цкоlogie der menschlichen Entwicklung. 1. Aufl. Stuttgart: Klett-Cotta.
3. Bronfenbrenner, U. (1986). Recent Advances in Research on the Ecology of Human Development. In R.-K. Silbereisen, K. Eyferth & G. Rudinger (Hrsg.), Development as 10 Action in Context - Problem Behaviour and Normal Youth Development (S. 287–310). Berlin: Springer.
4. OHS National Center on Parent, Family and Community Engagement, 2011. Verfügbar unter: <http://eclkc.ohs.acf.hhs.gov/hslc/tta-system/family>
5. Sylva, K., Melhuish, E., Sammons, P., Siray-Blatchford, I. & Taggart, B. (2004). The Effective Provision of Pre-School Education (EPPE) Project: Final Report. A longitudinal Study Funded by the DfES 1997-2004: Evidence & research.
6. In Deutschland z. B. „Elfra1“ und „Elfra2“: Grimm, H. & Doil, H. (2000). ELFRA. Elternfragebogen für die Früherkennung von Risikokindern. Guttingen, Bern, Toronto, Seattle: Hogrefe.; „EFkE“, Brandstetter, G., Bode, H. & Ireton, H. (2003). Elternfragebogen zur kindlichen Entwicklung. 1 - 6 Jahre : EFkE. Augsburg: Mцckl. Verfügbar unter <http://www.worldcat.org/oclc/643376017>.

THE CONTRIBUTION OF STRUCTURED OBSERVATION TO THE EFFECTIVENESS AND EFFICIENCY OF EDUCATIONAL MEASURES

Bernhard Nagel^a

^aPh.D, guest professor, Neubrandenburg University

Corresponding author: Bernhard.Nagel@extern.lrz-muenchen.de 

Abstract

While many participating countries are discussing the effectiveness and efficiency of their education systems and pedagogical approaches in the school sector with the help of international comparative studies (e.g. PISA studies), this is not yet the case in the pre-school sector. This is partly due to the rating of pre-school education, but also to suitable child-friendly methods/procedures.

Structured observation methods for child development are suitable for making valid and reliable statements on the development of a very large number of children in an economic way. This is an important condition for investigating the connection between educational policy measures and the developmental progress of children.

Using the example of the Mongolian child development observation sheets as well as a study on the effectiveness and efficiency of the use of additional funds in kindergarten in Germany, re-school education., it is shown how structured observation can help to assess the effectiveness and efficiency of pre-school education.

Keywords

Structured observation methods, effectiveness and efficiency of education.
